



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЦАГААННУУР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД

2024.08.07 № ГНАГ-2024/13-УТА-НА-14

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

- 018021003

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Цагааннуур сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (...⁵ хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Цагааннуур сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААНУУР СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024-2028

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААНУУР СУМ
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

ЦАГААНУУР СУМ
2024 ОН

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУИ**



МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.06.05

Цагааннуур сум

**ЦАГААННУУР НУТГАА
“ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд орон нутгийнхаа хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл иргэн – Амьдралын суурь

- 1.1 Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ажлыг эрчимжүүлнэ.
- 1.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.
- 1.3 Ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмжтэй болгох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах замаар шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ


Боловсролтой иргэн - Хөгжлийн суурь

- 2.1 Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяасад тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 2.2 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн эрүүл, аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 2.3 Орон нутагт дутагдалтай мэргэжлээр өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах багшид олгох дэмжлэгийг бий болгоно.
- 2.4 Хүүхэд багачуудыг улсын болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог тогтолцоог бий болгоно.
- 2.5 Хүүхэд хамгаалах, өдөр өнжүүлэх төвийг байгуулах ажлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ, УРЛАГ

Соёлтой иргэн – Ёс суртахууны суурь

- 3.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд соёлч Монгол иргэнийг сургаж, төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2 “Соёлч иргэн”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан хот, суурин соёлыг дэлгэрүүлнэ.
- 3.3 Цахим номын сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлнэ.
- 3.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ соёлын төв барих ажлыг жишиг зураг, төсвийн дагуу хийлгэхээр холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БИЕЙН ТАМИР, СПОРТ

Эрүүл, чийрэг иргэн – Идэвхтэй амьдрал

- 4.1 Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, орчныг бүрдүүлэх замаар эрүүл чийрэг амьдралын хэвшлийг төлөвшүүлэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 4.2 Сурагчдыг өвлийн спортоор хичээллэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- 4.3 Спорт цогцолборын барилгад засвар хийж, тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүнээр ханган иргэд спортоор хичээллэх ая тухтай орчинг бүрдүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН

Сэтгэл тайван иргэн – Аз жаргалтай амьдрал

- 5.1 Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгжүүлэх, хамгаалахад иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 5.2 Суманд үерийн хамгаалалтын далан, хур тунадасны ус зайлуулах суваг, хоолойг батлагдсан зураг төсвийн дагуу байгуулна.
- 5.3 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, байгаль орчинд хор нөлөөгүй үйлдвэрлэл эрхлэх иргэдийн санаачилгыг дэмжинэ.
- 5.4 Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий бэлэн байдлын цогц эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрч иргэн – Элбэг хангалуун амьдрал

- 6.1 Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.2 Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг, дунд, бичил бизнесийг дэмжин урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, шударга, ил тод хүртээмжтэй олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

- 6.4 Иргэдэд нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэгт чөлөөтэй үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Хүн төвтэй-хүмүүнлэг бодлоготой сум

- 7.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээнүүдэд байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.
- 7.2 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 7.3 Ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэгч сум болно.
- 7.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны ажлыг дэмжиж, байр танхимаар хангаж ажиллана.
- 7.5 Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн байртай болох ажлыг холбогдох байгууллагад уламжлан хэрэгжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

Аялал жуулчлал

- 8.1.1 Сумын аялал жуулчлалын маршрут баталж, зар сурталчилгааг сайжруулж хөгжүүлнэ.
- 8.1.2 Сумын иргэдийн соёл, ахуйн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 8.1.3 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтална.

Газар тариалан

- 8.2.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 8.2.2 Стратегийн хүнсний зориулалттай болон жимс жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 8.2.3 Тариалангийн үйлдвэрлэлд тэг болон цомхотгосон, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, байгальд ээлтэй бордооны хэрэглээг төлөвшүүлж, хөрсний үржил шимийг хамгаалж сайжруулна.
- 8.2.4 Тариалангийн ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бордоотой тариалалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 8.2.5 Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

8.3. Мал аж ахуй

- 8.3.1 Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангахад анхаарч, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 8.3.2 Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэргч амьтад, шавжтай тэмцэх, бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.
- 8.3.3 “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчин өрхийн амьжиргааг дэмжин, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулах замаар малчдын бодит орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 8.3.4 Хоршоололд суурилсан хамтын хариуцлага, хагас эрчимжсэн мал аж ахуйг бодлогоор дэмжин ажиллана.
- 8.3.5 Малчид, тариаланчдын шинэ үеийн залгамж халааг бэлтгэх бодлого хэрэгжүүлнэ.
- 8.3.6 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах бодлого баримталж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтарч ажиллана.
- 8.3.7 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогод дэмжлэг үзүүлнэ.
- 8.3.8 Баруун Харгистайн голыг боож хөв цөөрөм байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.
- 8.3.9 Өвс тэжээлийн фондыг хадгалах нэгдсэн агуулахтай болох ажлыг иргэн аж ахуй нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН


- 9.1 Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах, ойн хомсдол доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 9.2 Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдал, ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг бодитоор үнэлж дүгнэнэ.
- 9.3 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- 9.4 Хөндлөн булаг, Нянгайн рашаан зэрэг булаг, шанд, рашааны эхийг тохижуулна.

АРАВДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА

Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ

- 10.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 10.2 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж мэдээллийг ил тод, шилэн байлгана.

- 10.3 Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар танилцуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.
- 10.5 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 10.6 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.



АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ

- 11.1 Гэр хорооллыг инженерийн дэд бүтэцтэй холбож, дахин төлөвлөлтийг хийн орон сууцжуулах, төсөл, хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 11.2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерыг нэмэгдүүлж нэгдсэн төвд холбоно.
- 11.3 10 мвт-аас багагүй хүчин чадалтай нэгдсэн халаалтын төвтэй болох санхүүжилтийг холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлж, хэрэгжүүлнэ.
- 11.4 Бүсийн үйлчилгээний нэгдсэн төвтэй болох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.
- 11.5 Сум доторх зарим авто замыг хатуу хучилттай болгох ажлыг эрчимжүүлнэ.
- 11.6 Гэр хороололд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулна.
- 11.7 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.
- 11.8 Сум дундын Цагдаагийн тасагтай болох ажлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 11.9 Сум дундын Онцгой байдлын эрэн хайх, аврах салбартай болох ажлыг эрчимжүүлнэ.
- 11.10 Шүрэнгийн голд хурдан интернэтийн 4G сүлжээ тавих ажлыг хамтран хэрэгжүүлнэ.

Иргэдийнхээ хөгжих, тав тухтай, сэтгэл дүүрэн амьдарч ажиллах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван сум болно.

Цагааннуур сумын МАН-ын Хорооноос 2024 оны Цагааннуур сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа сум, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ хөдөлмөрч, дайчин, шударга уламжлалыг хадгалж, ирээдүй хойч үеийнхээ сайн сайхны төлөө Цагааннуур сайхан нутгаа "ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ".

ЦАГААННУУР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО